



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2022 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаяг эсхүл дээрх QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2022 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ	3
.....	
НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:	5
1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:	7
1.3 Бүтээмж, бүтээмжийн өсөлт:	7
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ	9
2.1. Нэгдсэн төсвийн орлого:	9
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага:	11
2.3. Төсвийн тэнцэл:	12
ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА	13
3.1. Гадаад худалдааны эргэлт:	13
3.2. Экспорт:	14
3.3. Импорт:	16
ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	17
4.1. Мөнгөний нийлүүлэлт:	17
4.2. Гадаад валютын албан нөөц:	18
4.3. Төлбөрийн тэнцэл:	19
ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	20
5.1. Хүн ам, ажил эрхлэлт:	20

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2022 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ



Эдийн засаг 3.8 хувиар буурсан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бодит ДНБ-ий хэмжээ 3.8 хувиар буурлаа. Үүнд уул уурхайн салбар 11.4 пункт, аж үйлдвэр, барилга 2.8 пункт, үйлчилгээ 0.8 пункт, тээвэр ба агуулахын үйлчилгээ 1.8 пунктээр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал нэмэгдсэн. 2022 оны эхний улирлын байдлаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт дүн 3,568.0 тэрбум төгрөг, төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 3,822.7 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 254.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. Өнгөрсөн оны мөн үеэс нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 940.2 тэрбум төгрөгөөр өссөн хэдий ч нэгдсэн төсвийн нийт зарлага 1,098.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал нэмэгдэхэд нөлөөлжээ.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2022 оны эхний улирлын гүйцэтгэлээр 3,822.7 тэрбум төгрөгт хүрч, 1,248.2 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай буюу 75.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 1,098.5 тэрбум төгрөгөөр буюу 40.3 хувиар нэмэгдсэн байна.

Төсвийн орлогын хувьд: 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 3,568.0 тэрбум төгрөгт хүрчээ. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өнгөрсөн оны мөн үеэс 940.2 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол тайлант хугацаанд орлогын төлөвлөгөө 357.6 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарлаа. 2022 оны эхний улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 3,632.7 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 3.1 хувь буюу 108.6 сая ам.доллороор өсөж, гадаад худалдааны тэнцэл 251.4 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Мөнгөний нийлүүлэлт өслөө. Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) 26.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 993.8 тэрбум төгрөгөөр буюу 3.9 хувиар өслөө. Үүнд гадаад валютын харилцах 22.0 хувиар өсч, төгрөгийн хадгаламж 4.6 хувиар буурсан нь нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс өссөн. 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр хэрэглээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 14.6 хувь байна.

Төлбөрийн тэнцэл алдагдалтай гарлаа. 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 972.4 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 648.7 сая ам.доллороор өсжээ.

Үнэт цаасны арилжаа буурчээ. 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр үнэт цаасны арилжаагаар 95.4 их наяд төгрөгийн гүйлгээ хийж, 96.3 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх

оны мөн үеэс гүйлгээ 29.5 тэрбум төгрөгөөр, арилжсан үнэт цаас 149.6 сая ширхгээр тус тус буурсан үзүүлэлт болж байна.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсан байна. 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах сарын нэрлэсэн дундаж ханш 2,901.8 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 52.2 төгрөгөөр суларсан байна. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 457.3 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 19.4 төгрөгөөр, өмнөх сараас 6.7 төгрөгөөр суларсан байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 969.3 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 75.8 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 313.3 тэрбум төгрөгөөр буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.4 хувийг эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 2.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 32.9 тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 103.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 9.6 хувийг эзэлж байна.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ


1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:

2022 оны эхний улирлын байдлаар бодит ДНБ-ий хэмжээ 5.2 их наяд төгрөг болж, эдийн засаг өнгөрсөн оны мөн үеэс 3.8 хувиар агшсан байна.

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ: 2021 оны эхний улиралд ДНБ-ий бодит өсөлт 14.8 хувьд хүрч их уналтын дараах сэргэлт (V хэлбэрийн сэргэлт) гарсан хэдий боловч энэхүү өсөлт 2021 оны туршид саарсан байна. Зураг 1-т 2016-2022 оны эхний улирлын ДНБ-ий хэмжээ болон мөн хугацааны улирал бүрийн эдийн засгийн бодит өсөлтийн хоорондох хамаарлыг харуулав.

Ийнхүү эдийн засгийн өсөлт удааширч, улмаар уналт бий болоход гадаад болон дотоодын хүчин зүйлс сэргээр нөлөөлсөн байна. Тухайлбал, дотоод хүчин зүйлсийн хувьд 2021 онд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал үргэлжилж Монгол Улсад хэд хэдэн удаагийн хатуу хөл хорио тогтоосон. Харин гадаад нөхцөл байдлын хувьд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор БНХАУ хилээ түр хаасан, 2022 оны эхэнд ОХУ, Украин улсуудын хоорондох нөхцөл байдал, зарим улс орнуудын Төв банкнаас мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлж эхэлсэн, тээвэр ложистик, хангамжийн сүлжээнд доголдол үүссэн, хүнсний хомсдол бий болсон зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлжээ.

Зураг 1. Нэрлэсэн ДНБ-ий хэмжээ ба ДНБ-ий бодит өсөлт, улирлаар



2022 оны эхний улиралд оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 9.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 4.0 хувь буюу 368.5 тэрбум төгрөгөөр өссөн бол 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ-ий хэмжээ 5.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.8 хувь буюу 208.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Оны үнээр тооцсон ДНБ-ий өөрчлөлтийг салбарын бүтцээр, өмнөх оны мөн үетэй харьцуулж авч үзвэл 2022 оны эхний улиралд уул уурхайн салбарын үйлдвэрлэл 15.5 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 6.9 хувь, барилгын салбарын үйлдвэрлэл 1.4 хувиар тус тус буурчээ.


Харин хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 23.9 хувь, үйлчилгээний салбар 12.0 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 25.3 хувиар тус тус нэмэгдсэн нь оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 4.0 хувиар өсөхөд эерэг нөлөө үзүүлжээ. 2022 оны эхний улиралд эдийн засгийн бодит өсөлт буурахад уул уурхайн салбар 37.1 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 33.7 хувь, барилга 29.9 хувь болон боловсруулах аж үйлдвэр 10.2 хувиар тус тус унасан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 1. ДНБ-ий бодит өсөлт, салбараар

	2020	2021	2020				2021				2022
			I	II	III	IV	I	II	III	IV	I
Эдийн засгийн өсөлт, салбараар /хувь/											
ДНБ-ийн бодит өсөлт	-4.6	1.4	-10.1	-8.9	-6.7	-4.6	14.8	6.3	3.6	1.4	3.8
Хөдөө аж ахуй	5.8	-5.5	12.0	12.4	10.8	5.8	-4.5	-4.6	-4.7	-5.5	11.3
Уул уурхай	-9.9	1.7	-32.9	-31.5	-22.1	-9.9	39.3	24.3	11.7	1.7	-37.1
Боловсруулах үйлдвэрлэл	3.5	0.3	1.2	-5.9	-5.8	3.5	24.6	12.7	6.4	0.3	-10.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1.8	9.4	5.5	2.3	1.1	1.8	6.8	9.2	9.1	9.4	6.1
Барилга	-3.2	-32.7	13.0	-1.8	-1.9	-3.2	-6.3	-39.7	-37.4	-32.7	-29.9
Бөөний болон жижиглэн худалдаа	-12.5	9.4	-13.6	-15.1	-14.8	-12.5	8.1	7.8	8.2	9.4	7.3
Тээвэр ба агуулах	-18.2	-16.7	-31.0	-32.2	-23.6	-18.2	12.1	2.5	-8.2	-16.7	-33.7
Мэдээлэл, холбоо	5.5	12.2	5.2	5.5	5.5	5.5	8.4	12.6	10.1	12.2	14.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	-2.6	4.6	-3.0	-4.3	-3.0	-2.6	1.0	0.7	2.4	4.6	3.8

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 2. ДНБ, өмнөх оны мөн үетэй харьцуулсан байдал /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны эхний улиралд эдийн засгийн өсөлт 14.8 хувьтай гарч байсан бол 2022 оны эхний улиралд 3.8 хувийн уналттай болж, эдийн засаг 18.6 пунктээр агшсан байна. Үүнд уул уурхайн салбар 11.4 пункт, аж үйлдвэр, барилга 2.8 пункт, үйлчилгээ 0.8 пункт, үүний дотор тээвэр ба агуулахын үйлчилгээ 1.8 пунктээр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. ДНБ-ий өөрчлөлтөд салбаруудын оролцоо, пунктээр

Салбараар	Эхний улирлын байдлаар		
	2021	2022	Өөрчлөлт, пунктээр
ДНБ-ий бодит өсөлт	14.8	-3.8	-18.6
- Хөдөө аж ахуй	-0.2	0.5	+0.7
- Уул уурхай, олборлолт	5.3	-6.1	-11.4
- Аж үйлдвэр, барилга	1.9	-0.9	-2.8
- Боловсруулах	1.7	-0.8	-2.4
- Барилга	-0.1	-0.4	-0.3
- Үйлчилгээ	2.0	1.1	-0.9
- Тээвэр ба агуулах	0.5	-1.3	-1.8
- Бүтээгдэхүүний цэвэр татвар	5.8	1.6	-4.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөө аж ахуй, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, үйлчилгээний салбар болон бүтээгдэхүүний цэвэр татвар 3.4 нэгж хувиар өсөлттэй гарсан бол бусад салбар /уул уурхай, аж үйлдвэр, барилга/-ын 7.2 нэгж хувийн бууралттай гарчээ.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ: Оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 2022 оны эхний улиралд 9.4 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 4.0 хувиар өссөн, харин 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 5.6 их наяд төгрөг болжээ.


Хүснэгт 3. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар /тэрбум төгрөгөөр/

Бүрэлдэхүүн	Эхний улирлын байдлаар				Зөрүү Хувь
	2019	2020	2021	2022	
ДНБ	7,665.2	7,133.6	9,084.9	9,444.7	4.0
Эцсийн хэрэглээ	6,166.3	6,975.7	6,316.1	7,613.7	20.5
Өрхийн хэрэглээ	5,031.9	5,659.7	5,147.0	6,317.8	22.7
Төрийн байгууллагын хэрэглээ	1,090.9	1,268.1	1,122.1	1,235.1	10.1
Хөрөнгийн нийт хуримтлал	1,980.9	2,003.6	2,491.0	3,307.9	32.8
Үндсэн хөрөнгийн хуримтлал	1,949.8	1,768.6	2,028.6	2,146.8	5.8
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	30.5	234.2	462.4	1,161.1	151.1
Цэвэр экспорт	- 482.0	- 1,845.7	277.9	- 1,476.9	-431.5
Бараа, үйлчилгээний экспорт	4,974.3	2,836.2	5,930.0	5,159.8	-13.0
Бараа, үйлчилгээний импорт	5,456.3	4,681.9	5,652.1	6,636.6	17.4

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 9.4 их наяд төгрөгт хүрч 4.0 хувиар өссөн хэдий ч 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 5.6 их наяд төгрөг болж 3.8 хувиар буурсан байна.

Зураг 3. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 4. ДНБ-ий бодит өсөлт, салбараар

Бүрэлдэхүүн	2020	2021	2020				2021				2022
			I	II	III	IV	I	II	III	IV	I*
Эдийн засгийн өсөлт, салбараар /хувь/											
ДНБ-ийн бодит өсөлт	-4.4	1.4	-7.3	-7.5	-6.0	-4.4	15.1	6.2	3.4	1.4	-3.8
Эцсийн хэрэглээ	4.5	-4.0	7.6	7.0	7.2	4.5	-11.4	-8.9	-8.3	-4.0	7.6
Өрх	2.1	-6.6	6.6	6.3	6.0	2.1	-11.6	-9.2	-8.4	-6.6	8.8
Засгийн газар	14.6	5.7	11.7	9.8	12.5	14.6	-10.6	-7.7	-8.0	5.7	2.3
Хөрөнгийн нийт хуримтлал	-40.7	74.1	-10.3	-25.2	-30.6	-40.7	29.2	44.7	78.2	74.1	15.4
Үндсэн хөрөнгийн хуримтлал	-21.1	14.0	-15.4	-20.7	-14.6	-21.1	12.2	12.6	2.8	14.0	-7.3
Материаллаг эргэлтийн хөрөнгө, хуримтлал	-112.3	-1,340.4	290.5	-54.6	-131.6	-112.3	249.4	412.9	-1,210.6	-1,340.4	109.1
Цэвэр экспорт	-43.4	119.6	43.2	25.6	4.3	-43.4	-47.3	-9.4	55.0	119.6	81.6
Экспорт	-5.3	-14.5	-42.6	-26.8	-19.6	-5.3	81.9	14.0	-9.0	-14.5	-25.7

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.2. Нэг ажилтанд ногдох ДНБ

Бүтээмжийг нэг хүнд ногдох бодит ДНБ-ээр илэрхийлдэг. Монгол Улсын хувьд 2015 оноос хойш улирал бүр уул уурхай, аж үйлдвэр, барилга, хөдөө аж ахуй болон үйлчилгээний салбарын бүтээмжийн талаарх статистик тоон мэдээллийг нийтэлдэг болсон. Энэхүү бүтээмжийг 2015 оны зэрэгцүүлэх үнээр нэг ажиллагчид ногдох ДНБ-ээр илэрхийлэн тооцоолж байна. 2022 оны эхний улиралд 4.3 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.2 хувиар буюу 490.1 мянган төгрөгөөр буурсан байна. Салбараар нь авч үзвэл хөдөө аж ахуйн салбарын бүтээмж 12.5 хувиар нэмэгдсэн боловч бусад салбарын бүтээмж буурсан үзүүлэлттэй байна. Ялангуяа уул уурхайн салбарын бүтээмж 44.9 хувь буюу 8.1 сая төгрөгөөр буурчээ. Бүтээмжийн бууралт нь уул уурхай, аж үйлдвэр, барилгын салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээ буурсантай холбоотой байна.


Хүснэгт 5. Нэг хүнд ногдох ДНБ буюу бүтээмжийн харьцуулалт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний улирлын байдлаар			(2022.I/2021.I) Өөрчлөлт		
	2019.I	2020.I	2021.I	2022.I	Дүн	Хувь
Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин	4,263.8	3,718.3	4,803.5	4,315.2	-488.3	-10.2%
Хөдөө аж ахуй	698.1	886.6	719.7	809.5	89.8	12.5%
Уул уурхай	15,292.5	11,803.8	18,230.5	10,040.2	-8,190.4	-44.9%
Аж үйлдвэр, барилга	3,541.6	3,309.4	4,098.5	3,184.2	-914.3	-22.3%
Үйлчилгээ	4,007.4	3,394.5	4,503.6	4,348.2	-155.5	-3.5%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2015-2022 оны эхний улирлын байдлаар уул уурхайн салбарын бүтээмж 2015 оноос хойш буурсан, харин хөдөө аж ахуйн болон үйлчилгээний салбарынх өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 4. Нэг ажилтанд ногдох бүтээмж, индексээр (2015=100)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2022 оны эхний улирлын байдлаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт дүн 3,568.0 тэрбум төгрөг, төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 3,822.7 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 254.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2022 оны эхний улиралд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 357.6 тэрбум төгрөг буюу 9.1 хувиар тасарсан, мөн төлөвлөгөөтэй харьцуулахад төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 1,248.1 тэрбум төгрөг буюу 24.6 хувиар дутуу биелсэн байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2022 оны эхний улиралд 3,568.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 940.1 тэрбум төгрөг буюу 35.8 хувиар, төсвийн нийт зарлага 1,098.6 тэрбум төгрөг буюу 40.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 6. Монгол Улсын нэгдсэн төсөв /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт, %	Өөрчлөлт(+/-)	
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	3,925.6	2,627.9	3,568.0	90.9%	940.1 35.8%
Нийт зарлага цэвэр зээлийн дүн	5,070.8	2,724.1	3,822.7	75.4%	1,098.6 40.3%
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1,145.2	-96.2	-254.7	22.2%	-158.5 164.7%
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь		-1.0%	-2.7%		-1.7%

Эх сурвалж: Сангийн яам

2022 оны эхний улирлын байдлаар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 254.7 тэрбум төгрөг болж тайлант хугацааны төлөвлөгөө 22.2 хувийн биелэлттэй гарсан буюу сайжирсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын хэмжээ 158.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж ДНБ-д эзлэх хэмжээ 2.7 хувь болж өмнөх оны мөн үеэс 1.7 пунктээр өндөр гарсан байна.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 3,568.0 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 35.8 хувиар буюу 940.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн, харин тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 357.6 тэрбум төгрөг буюу 9.1 хувиар дутуу биелсэн байна.

Тайлант хугацааны гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулахад 2022 оны эхний улирлын гүйцэтгэлээр улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 8.1 хувь буюу 193.1 тэрбум төгрөг, орон нутгийн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 20.8 хувь буюу 151.1 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 21.8 хувь буюу 78.9 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 4.3 хувь буюу 30.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэн байна.

2.1. Нэгдсэн төсвийн орлого

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2022 оны эхний улиралд улсын төсвийн орлого 24.5 хувь буюу 432.5 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого 7.0 хувь буюу 45.0 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн орлого 30.7 хувь буюу 66.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн, харин орон нутгийн төсвийн орлого 30.5 хувиар буюу 253.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Нэгдсэн төсвийн орлогын 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэл төсвийн шатлалаар /тэрбум төгрөг/

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,494.5	2,544.9	727.6	576.5	719.2	688.6	362.7	283.8
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	104.0	347.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,390.5	2,197.4	727.6	576.5	719.2	688.6	362.7	283.8
Татварын орлого	2,054.7	2,037.0	542.4	434.8	529.5	563.4	362.7	283.8
Татварын бус орлого	335.8	160.4	185.2	141.7	189.7	125.2	0.0	0.0


Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 94.3 хувийг татварын орлого, 5.7 хувийг татварын бус орлого эзэлж байна. Тайлант хугацаанд Тогтворжуулалтын санд 347.5 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 257.7 тэрбум төгрөг төвлөрсөн байгаагаас төлөвлөгөөтэй харьцуулахад Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлого биелсэн, харин Ирээдүйн өв санд төвлөрүүлэх орлого 68.4 хувийн биелэлттэй гарсан байна. Энэ нь уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээ буурсантай холбоотой байна.

Нэгдсэн төсвийн татварын орлого 3,363.9 тэрбум төгрөг болж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 7.7 хувиар буюу 282.3 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн, харин өмнөх оны мөн үеэс 40.1 хувь буюу 962.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Татварын орлого: Татварын орлогын 24.6 хувийг орлогын албан татвар, 18.9 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.5 хувийг хөрөнгийн албан татвар, 24.5 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 7.6 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 7.3 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 15.5 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

Зураг 5. Татварын орлого /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам


Тайлант хугацаанд татварын орлого төлөвлөснөөс 7.7 хувиар буюу 282.3 тэрбум төгрөгөөр дутуу биелэхэд орлогын албан татвар 3.3 хувь, нийгмийн даатгалын орлого 5.6 хувь, хөрөнгийн албан татвар 13.7 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 3.3 хувь, онцгой албан татвар 7.7 хувь, бусад татвар, төлбөр, хураамжийн орлого 23.6 хувиар тус тус дутуу төвлөрсөн нь голлон нөлөөлсөн байна. Харин тусгай зориулалтын орлого төлөвлөснөөс 60.7 хувь, гадаад үйл ажиллагааны орлого 0.2 хувиар тус тус давж биелсэн байна. Татварын орлого 282.3 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөний 57.1 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого, 23.3 хувийг орлогын албан татварын болон нийгмийн даатгалын орлого, 17.6 хувийг нэмэгдсэн болон онцгой албан татварын орлого эзэлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр татварын орлого 40.1 хувь буюу 962.3 тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 26.9 хувь, нийгмийн даатгалын орлого 38.9 хувь, хөрөнгийн албан татвар 20.6 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 26.5 хувь, онцгой албан татвар 20.5 хувь, тусгай зориулалтын орлого 48.6 хувь, гадаад үйл ажиллагааны орлого 20.5 хувиар тус тус өссөн, бусад татвар, төлбөр хураамж 1.9 дахинаар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Татварын бус орлого: Татварын бус орлогын 84.5 хувийг нийтлэг татварын бус орлого, 14.5 хувийг тусламжийн орлого, 1.0 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Татварын бус орлого 204.2 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 22.1 тэрбум төгрөгөөр буурсан, мөн тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 75.3 тэрбум төгрөг буюу 26.9 хувиар дутуу биелсэн үзүүлэлттэй байна. Энэхүү дутуу биелсэн дүнгийн 89.0 хувийг нийтлэг татварын бус орлого, 12.5 хувийг тусламжийн орлого эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад тусламжийн орлого 12.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн

Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 51.4 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 15.5 хувийг газрын тосны орлого, 12.3 хувийг торгуулийн орлого, 9.3 хувийг навигацгийн орлого, 5.8 хувийг хүүгийн орлого, 5.4 хувийг бусад орлого, 0.4 хувийг түрээсийн орлого тус тус эзэлж байна.

Зураг 6. Татварын бус орлогын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд төлөвлөгөөтэй харьцуулан үзэхэд хүүгийн орлого 6.8 тэрбум төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 7.4 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн, харин газрын тосны орлого 31.5 тэрбум, бусад орлого 32.5 тэрбум, торгуулийн орлого 7.8 тэрбум, навигацгийн орлого 7.5 тэрбум, хувьцааны ногдол ашиг 1.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна.

2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 5,070.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 75.4 хувийг зарлагадаж 1,248.2 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 1,098.5 тэрбум төгрөг буюу 40.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн зарлага /тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	ӨО-ны мөн үе	2022 оны эхний улирал			
		Төл.	Гүйц	Хувь	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,724.1	5,070.8	3,822.7	-24.6	-1,248.2
Нийт зарлага	2,703.4	5,249.8	3,818.8	-27.3	-1,431.0
Урсгал зардал	2,401.0	4,152.1	3,350.7	-19.3	-801.3
Бараа, ажил, үйлчилгээний зардал	880.6	1,213.5	762.5	-37.2	-451.0
Хүү	132.4	289.0	169.6	-41.3	-119.4
Татаас	79.0	202.7	134.0	-33.9	-68.7
Урсгал шилжүүлэг	1,309.0	2,446.9	2,284.7	-6.6	-162.2
Хөрөнгийн зардал	302.4	1,097.7	468.1	-57.4	-629.7
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	20.7	-179.0	3.9	-102.2	182.8

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 87.7 хувь буюу 3,350.7 тэрбум төгрөг нь урсгал зардал, үүний дотор 68.2 хувийг урсгал шилжүүлэг, 22.8 хувийг бараа, ажил, үйлчилгээний зардал, 5.1 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 4.0 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 949.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд бараа, ажил, үйлчилгээний зардал 118.2 тэрбум төгрөгөөр буурсан ч зээлийн үйлчилгээний төлбөр 37.2 тэрбум төгрөг, татаас 54.9 тэрбум төгрөг, урсгал шилжүүлэг 975.7 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. Түүнчлэн хөрөнгө оруулалтын зардал 165.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА

2022 оны эхний улирлын байдлаар экспортын худалдаа 1,942.0 сая ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 2.9 хувь буюу 58.4 сая ам.доллараар буурсан, харин импорт 1,690.7 сая ам.долларт хүрч 11.0 хувь буюу 167.0 сая ам.доллараар нэмэгдсэн нь гадаад худалдааны ашгийг 47.3 хувь буюу 225.3 сая ам.доллараар бууруулсан байна.

3.1. Гадаад худалдааны эргэлт:

2022 оны эхний улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 3,632.7 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 3.1 хувь буюу 108.6 сая ам.доллараар өссөн байна. Гадаад худалдааны нийт бараа эргэлт нэмэгдэхэд импортын дүн өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 9. Гадаад худалдааны үзүүлэлт /сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний улирлын байдлаар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт /өмнөх оны мөн үеэс/	
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	3,057.4	2,197.4	3,524.1	3,632.7	108.6	3.1
-Экспорт	1,771.7	1,035.8	2,000.4	1,942.0	-58.4	-2.9
-Импорт	1,285.7	1,161.6	1,523.7	1,690.7	167.0	11.0
Тэнцэл	485.9	-125.8	476.7	251.4	-225.3	-47.3


Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2022 оны эхний улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл 251.4 сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс гадаад худалдааны ашиг 225.3 сая ам.доллар буюу 47.3 хувиар буурахад импорт 167.0 сая ам.доллараар өсөж, экспорт 58.4 сая ам.доллараар буурсан нь нөлөөлсөн байна.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл: Валютын төлбөртэй экспорт нийт экспортын орлогын 98.4 хувь, валютын төлбөртэй импорт нь нийт импортын худалдааны 97.8 хувийг тус тус эзэлж байна. Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2022 оны эхний улирлын гүйцэтгэлээр 257.8 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 239.9 сая ам.доллаар буурсан байна. Валютын төлбөртэй барааны тэнцэл буурахад валютын төлбөртэй экспорт 61.8 сая ам.доллаар буурч, валютын төлбөртэй импорт 178.1 сая ам.доллаар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Экспорт, импортын жилийн өсөлт: Экспорт болон импортын жилийн өсөлтийн хурдыг 3 сарын дундаж (2011.01-2022.03)-аар тооцон үзэв. 2013 онд Оюутолгойн уурхайн төсөл эхэлж, олборлолт, борлуулалт хийснээр экспортын тоо хэмжээ 2014-2015 онуудад өссөн. 2020 оны эхний 5 сарыг эс тооцвол 2014 оноос хойш гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан байна.

Зураг 7. Гадаад худалдааны үзүүлэлт



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Гадаад худалдааны нийт бараа эргэлт, экспорт болон импортын худалдаанд хөрш ОХУ болон БНХАУ томоохон хувийг эзэлдэг. Тухайлбал, хөрш орнууд нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 72.4 хувь, экспортын 80.9 хувь, импортын 68.0 хувийг тус тус эзэлж байна. 2022 оны эхний улирлын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 56.4 хувь буюу 2,048.2 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай 16.1 хувь буюу 583.3 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийсэн байна. Харин бусад улс оронтой хийсэн худалдаа нь нийт бараа эргэлтийн 27.6 хувийг эзэлж байна. БНХАУ нийт экспортын 78.7 хувь /1.5 тэрбум ам.доллар/, нийт импортын 30.7 хувь /0.52 тэрбум ам.доллар/-ийг эзэлж байгаа бол ОХУ-ын хувьд нийт экспортын 2.2 хувь, нийт импортын 32.0 хувь /0.54 тэрбум ам.доллар/-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 10. Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт /сая ам.доллар/

	Төрөл	Жил бүрийн 1-р улирал (өссөн дүнгээр)			Өөрчлөлт (+, -) 2022.I/2021.I			Хувь
		Эзлэх хувь /2022.I улирал	2019	2020	2021	2022	Дүн	
БНХАУ	Нийт эргэлт	56.4%	1,887.7	1,236.9	2,440.8	2,048.2	-392.6	-16.1%
	Экспорт	78.7%	1,518.6	904.6	1,849.7	1,528.5	-321.1	-17.4%
	Импорт	30.7%	369.1	332.3	591.2	519.7	-71.5	-12.1%
	Тэнцэл		1,149.5	572.3	1,258.5	1,008.9	-249.6	-19.8%
ОХУ	Нийт эргэлт	16.1%	377.9	400.6	437.4	583.3	145.9	33.4%
	Экспорт	2.2%	14.9	11.0	27.8	42.8	15.0	54.0%
	Импорт	32.0%	363.0	389.6	409.6	540.5	130.9	32.0%
	Тэнцэл	-	-348.1	-378.6	-381.8	-497.7	-115.9	30.4%
Бусад	Нийт эргэлт	27.6%	791.9	559.9	645.9	1,001.2	355.3	55.0%
	Экспорт	19.1%	238.2	120.2	123.0	370.7	247.7	201.5%
	Импорт	37.3%	553.6	439.7	522.9	630.5	107.6	20.6%
	Тэнцэл	-	-315.4	-319.5	-400.0	-259.9	140.1	-35.0%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

3.2 Экспорт

Экспортын худалдаа 2022 оны эхний улирлын гүйцэтгэлээр 1,942.0 сая ам.доллар болж, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас өмнөх буюу 2019 оны мөн үетэй харьцуулахад 170.4 сая ам.доллар буюу 9.6 хувиар өссөн бол 2021 оны мөн үетэй харьцуулахад 58.4 сая ам.доллар буюу 2.9 хувиар буурсан байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 1,531.3 сая ам.доллар болж, өмнөх оноос 244.9 сая ам.доллар буюу 13.8 хувиар буурсан, харин эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 410.7 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 186.5 сая ам.доллар буюу 83.2 хувиар өссөн байна. Эрдсийн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жин 2022 оны эхний улиралд 78.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 9.9 пунктээр буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь эрдсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ буурсантай холбоотой.


Хүснэгт 11. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт /сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний I улирлын гүйцэтгэл (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	1,478.9	886.0	1,776.2	1,531.3	-244.9	-13.8	78.9
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	292.7	149.8	224.2	410.7	186.5	83.2	21.1
Нийт экспорт	1,771.7	1,035.8	2,000.4	1,942.0	-58.4	-2.9	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Экспортын орлогын 7-оос багагүй хувийг эзэлдэг бүтээгдэхүүнд зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдэр, алт болон боловсруулаагүй нефть багтаж байна.


ЗУРАГ 8. Гол нэр төрлийн барааны экспорт /сая ам.доллар/



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Зураг 9: Зэсийн баяжмалын экспортын өөрчлөлт, сараар

Зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдрийн экспортын орлого, тоо хэмжээ болон үнийн өөрчлөлтийг бүтээгдэхүүн бүрээр доор харууллаа.



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Зураг 10. Нүүрсний экспортын өөрчлөлт, сараар



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Зураг 11. Төмрийн хүдрийн экспортын өөрчлөлт, сараар



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 12. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	Эхний I улирлын гүйцэтгэл (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
		2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	361.4	306.6	316.3	334.8	18.5	5.8
Нүүрс	сая.тн	7.7	3.1	6.7	2.5	-4.1	-62.2
Төмрийн хүдэр	сая.тн	2.1	2.1	1.9	0.6	-1.3	-67.8
Цайрын баяжмал	мян.тн	44.0	36.9	31.0	21.9	-9.1	-29.5
Алт	тн	4.7	1.6	0.4	4.8	4.4	989.3
Боловсруулаагүй нефть	сая. баррель	1.6	0.3	1.4	0.0	-1.4	-100.0
Катодын зэс	тн	2.3	3.1	3.3	0.8	-2.5	-76.8
Жоншны баяжмал	мян.тн	110.6	137.1	194.1	50.9	-143.2	-73.8
Адууны мах	мян.тн	5.8	2.7	4.2	0.0	-4.2	-100.0
Өлөн гэдэс	тн	102.0	125.5	171.4	129.4	-42.0	-24.5
Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	18.6	19.7	1.0	0.2	-0.8	-78.2
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	0.0	62.0	355.6	0.7	-354.9	-99.8
Хонь, хургааны боловсруулсан арьс	сая.дм2	6.3	9.3	3.756	0.0	-3.8	-100.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	72.8	48.5	30.0	29.3	-0.8	-2.5
Самнасан ноолуур	тн	24.4	17.9	355.1	102.7	43.8	74.4
Бохир ноолуур	тн	11.9	45.0	58.9	722.3	663.4	1,126.5
Хонины самнаагүй ноос	мян.тн	3.2	1.6	3.0	0.1	-2.9	-97.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 13. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого /сая ам.доллар/

Барааны төрөл	Эхний улирлын гүйцэтгэл				Өмнөх оны мөн үеэс	
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	503.7	351.2	621.1	710.9	89.8	14.5
Нүүрс	641.7	252.4	688.7	675.6	-13.1	-1.9
Төмрийн хүдэр	106.5	141.1	238.5	57.5	-181.1	-75.9
Цайрын баяжмал	62.6	48.3	46.4	41.2	-5.2	-11.3
Алт	195.9	80.4	25.7	288.0	262.3	1022.5
Боловсруулаагүй нефть	87.8	17.7	78.4	0.0	-78.4	-100.0
Катодын зэс	13.7	17.3	27.3	7.4	-19.9	-72.8
Жоншны баяжмал	40.6	35.3	42.6	11.5	-31.1	-73.0
Адууны мах	10.6	5.5	8.6	0.0	-8.6	-100.0
Өлөн гэдэс	2.4	2.2	3.8	3.5	-0.3	-6.7
Үхэр, адууны боловсруулсан шир	1.8	1.8	0.4	0.12	-0.3	0.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.0	0.1	0.6	0.02	-0.6	-97.1
Хонь, хургааны боловсруулсан арьс	0.13	0.2	56.2	1.3	1.3	2.3
Ямаа, ишигийн боловсруулсан арьс	2.4	2.0	1.0	0.5	-0.5	-47.5
Самнасан ноолуур	2.3	0.8	11.2	12.1	0.9	8.2
Бохир ноолуур	0.6	4.0	3.3	32.8	29.5	886.6
Хонины самнаагүй ноос	5.5	1.7	2.9	0.2	-2.7	-94.2
Нийт экспортод эзлэх хувь	94.7%	92.9%	90.0%	94.9%		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Нийт экспортын 34.8 хувийг нүүрс, 36.6 хувийг зэсийн баяжмал, 3.0 хувийг төмрийн баяжмал, 14.8 хувийг алт эзэлж эдгээр эрдсийн бүтээгдэхүүнүүдийн нийлбэр нь нийт экспортын 89.2 хувийг бүрдүүлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 244.9 сая ам.доллар буюу 13.8 хувиар буурахад голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

Нүүрс: 2022 оны эхний улирлын гүйцэтгэлээр 2.5 сая тонн нүүрс экспортолж, 675.6 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үеэс нүүрсний үнэ 270.2 ам.доллар/тн болж, 2.6 дахин өссөн боловч хил гаалийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан экспортын биет хэмжээ 4.3 сая тонноор буурсан нь нүүрсний экспортын орлого 16.7 сая ам.доллар буюу 1.9 хувиар багасахад нөлөөлсөн байна.

Зэсийн баяжмал: 2022 оны эхний улирлын гүйцэтгэлээр зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 14.5 хувь буюу 89.8 сая ам.доллаар өсөж 710.9 сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ 334.8 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 5.8 хувь буюу 18.5 мянган тонноор нэмэгдсэн, мөн зэсийн баяжмалын экспортын дундаж үнэ 8.1 хувиар өссөн зэрэг нь зэсийн баяжмалын экспортын орлогыг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлжээ.

Төмрийн хүдэр: 2022 оны эхний улирлын гүйцэтгэлээр 616.2 мянган тонн төмрийн хүдэр экспортолж 57.5 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 75.9 хувь буюу 181.1 сая ам.доллаар буурахад төмрийн хүдрийн биет хэмжээ 68.4 хувь буюу 1.3 сая тонноор буурсан, мөн нэг тонн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 23.7 хувь буюу 29.8 ам.доллар/тн-аар буурсанаас гадна хил гааль, тээвэр ложистикийн хүндрэлтэй нөхцөл байдал зэрэг нь нөлөөлсөн байна.

Цайрын баяжмал: 2022 оны эхний улирлын гүйцэтгэлээр цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ 21.9 мянган тоннд хүрч, 41.2 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Нэг тонн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 25.7 хувиар нэмэгдсэн боловч цайрын баяжмалын биет хэмжээ 29.5 хувь буюу 9.1 мянган тонноор буурсан нь цайрын баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 11.3 хувь буюу 5.2 сая ам.доллаар буурахад нөлөөлжээ.

Алт: 2022 оны эхний улирлын гүйцэтгэлээр 4.8 тонн алт экспортолсон нь сүүлийн 11 жилийн хугацаан дахь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Алтны экспортын орлого 288.0 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 11 дахин нэмэгдсэн байна. Экспортолсон алтны үнэ өмнөх оны мөн үеэс 6.8 хувь буюу 4.4 сая ам.доллар/тн -аар буурсан хэдий ч алтны экспортын биет хэмжээ нэмэгдсэн нь алтны экспортын орлогыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна. Алтны экспортын орлого нэмэгдсэн нь эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх, гадаад валютын ханшийг тогтвортой байлгахад эерэгээр нөлөөлсөн.

Катодын зэс буюу тунгаасан зэс ба хайлш: 2022 оны эхний улирлын гүйцэтгэлээр 0.8 тонн катодын зэс экспортолж 7.4 сая ам.долларын орлого олсон бөгөөд экспортын орлого нь өмнөх оны мөн үеэс 72.8 хувь буюу 19.9 сая ам.доллаар буурсан. Нэг тонн тунгаасан зэсийн экспортын дундаж үнэ 11.8 хувиар нэмэгдсэн боловч экспортын тоо хэмжээ буурсан байна.

3.3. Импорт

2022 оны эхний улирлын байдлаар нийт импортын худалдаа 1,690.7 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 11.0 хувь буюу 167.0 сая ам.доллаар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт импортын 22.9 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 77.1 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний импорт 386.5 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 109.7 сая ам.доллаар буюу 39.6 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 1,304.2 сая ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 57.3 сая ам.доллар буюу 4.6 хувиар өсчээ.

Хүснэгт 14. Эрдсийн бүтээгдэхүүний импорт

Үзүүлэлт	Эхний I улирлын гүйцэтгэл (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	315.4	284.0	276.8	386.5	109.7	39.6	22.9
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	970.3	877.5	1,246.9	1,304.2	57.3	4.6	77.1
Нийт импорт	1,285.7	1,161.6	1,523.7	1,690.7	167.0	11.0	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар


Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн 22.9 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 15.9 хувь, авто болон агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 13.1 хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл 15.4 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 9.4 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 7.4 хувийг тус тус эзэлж байна.

2022 оны эхний улирлын байдлаар импортын 36.0 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 32.1 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 12.1 хувийг аж үйлдвэрлэлийн орц, 19.5 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлсэн байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт нь өмнө оны мөн үеэс 100.0 сая ам.доллаар өссөн байна. Үүнд нефтийн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлт нөлөөлжээ. Дизель түлшний импорт 15.0 сая ам.доллар, бензин 88.0 сая ам.доллаар нэмэгджээ. 2022 оны эхний улиралд нефтийн бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 114.0 ам.дол/баррель болсон байна.

Импорт нэмэгдэхэд хэрэглээний бүтээгдэхүүн 163.0 сая ам.доллар, нефтийн бүтээгдэхүүн 100.0 сая ам.доллаар тус тус өссөн, нь голлон нөлөөлжээ. Харин хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 92.0 сая, аж үйлдвэрийн орц 6.0 сая ам.доллаар тус тус буурсан байна. Үүний дотор машин, тоног төхөөрөмж, түүний эд анги 173.0 сая ам.доллаар буурсан байна. Харин дизель, АИ-92,95 бензин 103.0 сая ам.доллаар, түргэн эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 94.0 сая ам.доллар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 69.0 сая ам.доллар, барилгын материал 7.0 сая ам.доллаар нэмэгдсэн байна.

Зураг 12. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ



Хүснэгт 15. Гол нэр төрлийн импорт барааны гүйцэтгэл

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Бүтээгдэхүүн	Эхний улирлын гүйцэтгэл						Өөрчлөлт 2022.I/2021.I
	2020		2021		2022		
	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	
Хэрэглээ	317.0	27.3	446.0	29.3	609.0	36.0	163.0
-Түргэн эдэлгээтэй	175.0	15.1	252.0	216.5	346.0	20.5	94.0
-Удаан эдэлгээтэй	142.0	12.2	194.0	12.7	263.0	15.6	69.0
Хөрөнгө оруулалт	461.0	39.7	634.0	41.6	542.0	32.1	-92.0
-Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	323.0	27.8	469.0	30.8	296.0	17.5	-173.0
-Барилгын материал	97.0	8.4	107.0	7.0	184.0	10.9	77.0
-Хөрөнгө оруулалтын бусад бараа	41.0	3.5	58.0	3.8	62.0	3.7	4.0
Аж үйлдвэрлэлийн орц	143.0	12.3	210.0	13.8	204.0	12.1	-6.0
- Химийн бүтээгдэхүүн	23.0	2.0	26.0	1.7	41.0	2.4	15.0
-Цахилгаан эрчим хүч	38.0	3.3	41.0	2.7	46.0	2.7	5.0
Нефтийн бүтээгдэхүүн	238.0	20.5	230.0	15.1	330.0	19.5	100.0
-Дизель	125.0	10.8	136.0	8.9	151.0	8.9	15.0
-АИ-92, 95	63.0	5.4	50.0	3.3	138.0	8.2	88.0
-А80 ба бусад	50.0	4.3	44.0	2.9	41.0	2.4	-3.0
Нийт дүн	1,161.6	100.0	1,523.7	100.0	1,690.7	100.0	167.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Мөнгөний нийлүүлэлт:

Мөнгөний нийлүүлэлт 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 26,507.3 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 1,074.2 тэрбум төгрөг буюу 3.9 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үеэс мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд М1 мөнгө 1,406.0 тэрбум төгрөг буюу 32.4 хувиар өссөн нь нөлөөлжээ. Харин төгрөгийн хадгаламж 4.6 хувь буюу 665.6 тэрбум, валютын хадгаламж 3.7 хувь буюу 166.5 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна. 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар валютын хадгаламж 4.3 их наяд төгрөг, төгрөгийн хадгаламж 13.7 их наяд төгрөг байна.

Хүснэгт 16. Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Эхний улирлын гүйцэтгэл			Өөрчлөлт (+/-) 2022/2021	
	2020	2021	2022	Дүн	Хувь
Мөнгөний нийлүүлэлт (M2)	20,692.2	25,433.4	26,507.3	1,074.2	3.9
Бараг мөнгө	17,218.7	21,091.4	20,759.6	-331.8	-1.6
- Төгрөгийн хадгаламж	10,872.3	14,367.3	13,701.7	-665.6	-4.6
- Валютын хадгаламж	3,755.3	4,447.1	4,280.6	-166.5	-3.7
- Валютын харилцах	2,591.1	2,277.0	2,777.4	500.4	21.9
M1 мөнгө	3,473.5	4,342.0	5,748.0	1,406.0	32.4
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө	847.8	1,006.0	994.0	-12.0	1.2

Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 22.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 797.0 тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 4.5 их наяд төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 17. Зээлийн өрийн үлдэгдэл /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жил бүрийн нэгдүгээр улирлын байдал			Өөрчлөлт (+/-) 2021/2022	
	2020	2021	2022	Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	17,146.5	17,636.4	22,086.6	4,450.2	25.2
- Хэвийн зээл	14,163.3	14,333.2	18,992.8	4,659.6	32.5
- Хугацаа хэтэрсэн зээл	1,150.3	1,282.5	969.3	-313.2	24.4
- Чанаргүй зээл	1,832.9	2,020.7	2,124.5	103.8	5.1
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	10.6	11.4	9.6	-1.7	7.9
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	6.7	7.2	4.3	-2.9	40.3

Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 51.9 хувь нь иргэдийнх, 46.0 хувь нь хувийн байгууллагынх, 1.3 хувь нь төрийн байгууллагынх, 0.8 хувь нь санхүүгийн болон бусад байгууллагынх байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 969.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 313.3 тэрбум төгрөгөөр буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.3 хувийг эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 2.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 103.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 9.6 хувийг эзэлж байна.

Үнэт цаас: Үнэт цаасны арилжаагаар 2022 оны эхний улирлын байдлаар 95.4 их наяд төгрөгийн гүйлгээ хийж, 96.3 сая ширхэг үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеэс гүйлгээ 29.5 их наяд төгрөгөөр, арилжсан үнэт цаас 149.4 сая ширхэгээр буурсан үзүүлэлт болж байна. Үнэт цаасны гүйлгээ 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 13.9 тэрбум төгрөг болжээ. Арилжсан үнэт цаас 20.3 сая ширхэг болж, өмнөх сараас 47.6 сая ширхэгээр буурчээ. Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 38,023.4 нэгж болж өмнөх оны мөн үеэс 4,071.2 нэгжээр өссөн байна.

Валютын ханш: 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж 2,901.8 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 53.2 төгрөгөөр суларсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 457.23 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 19.45 төгрөгөөр суларчээ.

Зураг 13. АНУ-ын доллар ба БНХАУ-ын юань дундаж ханш, төгрөгөөр, 1 дүгээр улирлын байдлаар



Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2022 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 14.6 хувь байна.

Зураг 14. Хэрэглээний үнийн улсын индекс, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, хувиар




Эх сурвалж: Монголбанк

4.2. Гадаад валютын албан нөөц:

Нийт албан нөөцийн хэмжээ 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 3,318.6 сая ам.доллар болж өмнөх сараас 9.9 хувь буюу 366.3 сая, өнгөрсөн оны мөн үеэс 30.5 хувь буюу 1,456.0 сая ам.доллороор тус тус буурсан байна.

Зураг 15. Нийт гадаад валютын албан нөөц, сая ам.доллар, сараар



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 3,318.6 сая ам.доллар болж импортын 2 сарын хэрэгцээг хангах түвшинд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад импортын хэмжээ өссөн, гадаад валютын албан нөөц буурсан зэрэг нь импортын хэрэгцээг хангах түвшинг 1.1 пунктээр бууруулахад нөлөөлсөн байна.


Хүснэгт 18. Гадаад валютын албан нөөц ба импорт /сая ам.доллар/

Үзүүлэлт	Жил бүрийн эцсийн байдал				Өөрчлөлт (+/-)	
	2017.I	2018.I	2019.I	2020.I	2021/2022	
Нийт импорт	776.2	1,130.5	1,285.7	1,161.6	1,523.7	1,690.7
Гадаад валютын нийт нөөц	1,109.2	2,983.1	3,660.4	4,094.2	4,774.6	3,318.6
Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/	1.4	2.6	2.8	3.5	3.1	2

Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны худалдан авсан алтны нөөц 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 3.4 тонн болж, өмнөх оны мөн үеэс 0.5 тонн буюу 18.3 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 16. Худалдан авсан алтны хэмжээ, жилийн бүрийн нэгдүгээр улирлын байдлаар /кг/



Эх сурвалж: Монголбанк

4.3. Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2022 оны эхний улирлын байдлаар урсгал тэнцэл 397.4 сая ам.долларын, хөрөнгө ба санхүүгийн тэнцэл мөн 58.43 сая ам.долларын алдагдалтай гарсан нь төлбөрийн тэнцэл нийт дүнгээрээ 382.2 сая ам.долларын алдагдалтай гарахад нөлөөлжээ. Төлбөрийн тэнцэл өнгөрсөн оны мөн үед 163.4 сая ам.долларын ашигтай байсан бол 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 382.2 сая ам.долларын алдагдалтай байна.

2022 оны эхний улирлын байдлаар урсгал тэнцлийн алдагдал 397.4 сая ам.доллар байна. Урсгал тэнцлийн хувьд бараа ба үйлчилгээний худалдааны тэнцэл 252.9 сая ам.долларын, мөн цэвэр орлого 168.4 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Харин цэвэр урсгал шилжүүлэг 24.0 тэрбум ам.долларын ашигтай гарсан бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал тэнцлийн алдагдал 271.1 сая ам.доллороор нэмэгдсэн байна.

2022 оны эхний улирлын байдлаар урсгал тэнцлийн алдагдал 397.4 сая ам.доллар байна. Урсгал тэнцлийн хувьд бараа ба үйлчилгээний худалдааны тэнцэл 252.9 сая ам.долларын, мөн цэвэр орлого 168.4 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Харин цэвэр урсгал шилжүүлэг 24.0 тэрбум ам.долларын ашигтай гарсан бол өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал тэнцлийн алдагдал 271.1 сая ам.доллароор нэмэгдсэн байна.

Урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэхэд бараа, үйлчилгээний худалдаа болон цэвэр орлогын гадагшлах урсгал нэмэгдсэн зэрэг нь нөлөөлсөн байна. 2022 оны эхний улирлын байдлаар хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 58.43 сая ам.долларын алдагдалтай гарч өмнөх оны мөн үеэс 175.2 сая ам.доллароор буурсан байна. Төлбөрийн тэнцэл 382.2 тэрбум ам.долларын алдагдалтай гарч өнгөрсөн оны мөн үеэс 545.6 сая ам.доллароор нэмэгдсэн байна.

Хүснэгт 19. Төлбөрийн тэнцэл,
2020-2022 оны эхний улирал
/сая ам.доллар/

Барааны төрөл	Жил бүрийн нэгдүгээр улирлын байдал			Өмнөх оны мөн үеэс	
	2020	2021	2022	Дүн	Хувь
I. Урсгал Тэнцэл	-322.8	-126.3	-397.4	-271.0	68.2%
А. Бараа ба худалдаа	-290.3	-11.2	-252.9	-241.7	21.8 дахин
В. Орлого	-44.1	-134.9	-168.4	-33.5	24.8%
С. Урсгал шилжүүлэг (цэвэр)	11.6	19.8	24.0	4.15	21.0%
II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл	-13.7	-233.6	-58.4	175.21	-75.0%
А. Хөрөнгийн данс	8.9	11.3	15.4	4.05	35.8%
В. Санхүүгийн данс	-22.6	-245.0	-73.8	171.2	-69.9%
III. Алдаа болон орхигдуулга	23.9	33.5	-74.1	-107.53	-321.2%
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	-267.4	163.4	-382.2	-545.6	-

Эх сурвалж: Монголбанк

ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ


5.1. Хүн ам, ажил эрхлэлт

2022 оны эхний улирлын байдлаар улсын хэмжээнд 13.8 мянган хүүхэд шинээр төрж, төрсөн хүүхэд өмнөх оны мөн үеэс 3.9 мянгаар буурчээ. Нийт 2,125.7 мянган хөдөлмөрийн насны хүн байгаагаас 1,232.9 мянган хүн нь ажиллах хүчинд хамаарч байна. Ажиллах хүчнээс 1,128.5 мянган хүн нь ажилтай, 104.4 мянган иргэд нь ажилгүй хүмүүс байна. Улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин 58.0 хувь, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 53.1 хувьтай байна. Мөн 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн ам 892.8 мянга байна. 2021 оны эцэстэй харьцуулахад уул уурхай, барилга, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, зочид буудал зэрэг салбарын ажиллагсдын тоо хэмжээ буурсан байна.

5.2. Ажилгүйдлийн түвшин

2022 оны эхний улиралд улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 8.5 хувьтай болж, өмнөх оны мөн үеэс 0.3 пунктээр нэмэгдсэн, ажил идэвхтэй хайж байгаа бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өссөн үр дүн гарсан байна.

Зураг 16. Ажилгүйдлийн түвшин, жилийн бүрийн нэгдүгээр улирлын байдлаар, хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС